



МОНГОЛ



Эрхэд суурилсан боловсрол сургалтын оролцогчид (2024)

ТОДРУУЛАГЧ ТАЙЛАН: МОНГОЛ УЛС ДАХЬ ТХЗ 4-ИЙН ХЭРЭГЖИЛТ (2024)

I. УЛС ОРНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол нь БНХАУ болон ОХУ-ын дунд орших хүн ам багатай, өргөн уудам нутагтай улс юм. 2022 оны байдлаар Монгол улсын хүн ам 3.5 саяд хүрсэн (2019 оноос дунджаар 0.2 саяар хүн ам нэмэгдсэн) ба энэ хугацаанд хот дахь хүн ам 68%-иас 70% болж өссөн байна.

Монгол Улсын эдийн засаг эрчимтэй хөгжиж байгаа ба үүнийг эдийн засгийн тогтвортой өсөлт, хөдөлмөрийн бүтээмж мэдэгдэхүйц нэмэгдсэнээс нь харж болно. Гэсэн хэдий ч коронавируст (COVID-19) цар тахлын улмаас 2021 онд дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 4.4 хувиар, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 5.0 хувиар буурч, эдийн засаг томоохон уналтад орсон. Хүн амын 63 орчим хувь нь 15-64 насны бүлэгт багтах бөгөөд 2022 оны байдлаар уг бүлгийн дөнгөж 58 орчим хувь нь ажил эрхэлж байна. Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн зах зээл дэх оролцоо (50%-г эрэгтэйчүүдийн оролцоо (65%)-той харьцуулахад доогуур байна. Монгол улсын эдийн засаг нь голчлон уул уурхай, барилга, хөдөө аж ахуй, үйлчилгээний салбарт суурилдаг.

Монгол улс 1.56 сая км² газар нутагтай бөгөөд 2017 онд хүн амын дундаж нягтрал хөдөө орон нутагт нэг км² тутамд 2 хүн ногддог ба энэ нь нийслэл Улаанбаатараас эрс ялгаатай юм –Улаанбаатар хотод нэг км² талбайд 311.3 хүн ногдож байжээ (БСҮХ, 2019). Монгол орон нь ойт хээр, уулын, цөлөрхөг хээр, цөл гэсэн дөрвөн байгалийн бүсээс бүрддэг. Өвөл нь урт, хүйтэн ба зун нь богино байдаг эх газрын эрс тэс уур амьсгалтай. 4 улирлын онцлогоос улс орны нийгмийн амьдрал болон эдийн засгийн байдал хүчтэй хамааралтай. Дундаж температур 11-р сараас 3-р сар хүртэл 0 хэмээс доогуур байдаг. 1, 2-р сарын дундаж температур -20°C, зуны улиралд говийн бүсийн өмнөд хэсгээр 38°, нийслэл Улаанбаатарт 33° хүртэл халдаг. Монгол улсын талаас илүү хувийг эзлэх мөнх цэвдэг нь зам, барилга, уул уурхайн салбарт хүндрэл учруулдаг. Хур тунадасны хэмжээ ерөнхийдөө бага байдаг: хамгийн их хур тунадас болох 250-390 мм нь Алтайн нуруунд, хамгийн бага буюу 70-150 мм нь говь цөлд ордог (БСҮХ, 2019).

Монгол орны газарзүйн байршил, эмзэг экосистем нь уур амьсгалын өөрчлөлтөд өртөмтгий.

Сүүлийн 70 жилийн хугацаанд агаарын дундаж температур 2.07°C-аар нэмэгдэж, Монгол Улс 2014 оны уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг байдлын индексээр 100 гаруй орноос 8-р байранд жагсчээ (Крефт, Экштейн, 2014). Уур амьсгалын өөрчлөлт, түүнээс гарах үр дагаврыг бууруулах нь улс орны хөгжилд тулгамдсан асуудал болоод байна.

II. ТХЗ-4-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ГАРЧ БУЙ АХИЦ ДЭВШИЛ

Монгол улсад боловсролын салбарын хувьд сурагчдын хамран сургалт өндөр түвшинд хүрч, бүх шатны боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх стратегийг хэрэгжүүлж, томоохон ахиц дэвшил гарсан. Монгол Улсын Засгийн Газар боловсролын салбарт ихээхэн анхаарал хандуулж, 2022 онд ДНБ-ий 4.3 хувь буюу улсын төсвийн нийт зардлын 12.8 хувийг зарцуулсан. Монгол улс даяар бүх нийтээр суурь боловсролд 98% хамрагдсан нь ялангуяа бага, дунд ангийн хүрээнд боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх стратеги амжилттай хэрэгжиж байгаагийн нотолгоо болж байна. 2022 оны хичээлийн жилд нийт 859 сургууль буйгаас 688 буюу 80% нь төрийн өмчийн сургууль байна.

Хөдөө орон нутагт сургуулиуд өргөжин тэлж, эцэг эхчүүд хүүхдийнхээ боловсролд анхаарч байгаа бөгөөд дунд сургуульд хамран суралцах сурагчдын тоо жилээс жилд нэмэгдсээр байна. Томоохон ахиц дэвшилт гарсан хэдий ч сургалтын чанар муу байгаа, багш нарын өсөн нэмэгдэж байгаа ачаалал зэрэгт хангалттай ач холбогдол өгөхгүй байна. Тухайлбал, сургалтын чанар, дотуур байрны нөхцөл болон сургуулиас гадуурх үйл ажиллагааг сайжруулах зэрэг томоохон сорилтууд байсаар байна. Түүнчлэн сургалтын хөтөлбөр, сурах бичгийн чанар, сургалтын үр дүн, боловсролын салбар дахь жендэрийн хэвшмэл ойлголт, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг тэгш хамруулан сургах боломж, сургууль төгссөний дараах академик болон ажил мэргэжлийн ахиц дэвшил, сургуулийн удирдлага сургалтын шинэлэг хандлагыг дэмжих нь бага, байгууллагын хэвшмэл соёл, хот хөдөөгийн ялгаа, дэд бүтэц сул гэх мэт бусад асуудлууд бий.

Монгол улсын тухай баримт, түүн үзүүлэлт	
Хүн ам	3,398,366 (2022)
Нэг хүнд ноогдох үндэсний нийт орлого	16,390 (2023)
Орлогын бүлэг	Дундаж
ХХИ: зэрэглэл	0.741 96-143 (2022)
Жини индекс	31.4 (2022)
Боловсролын зардал (%ДНБ)	4.26% (2022)
Бүрэн дунд боловсролын үзүүлэлт	77.3 (2018)
Эрэгтэй/ эмэгтэй	82.0 / 72.5
Бичиг үсэг тайлагдсан түвшин (15-64 нас)	99.2 (2020)
Эрэгтэй/ эмэгтэй	99.2/ 99.1
2024 ТХЗ	66.31
Оноо/ түвшин	99-166
ТХЗ 4 хандлага	■ Сорилтууд хэвээр
ТХЗ 4 хяналт	↑ Дундаж өсөлттэй

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гамшиг:

Нийт дүн:	8 (2020-22)
Бүс нутгийн гамшигийн дундаж хэмжээ	9.3/ 4

Гамшигийн менежментийн индекс:

Уур амьсгалаас үүдэлтэй аюул/ халдварт өвчин	4.2 (2022) Бүс нутгийн дундаж 4.6
Даван туулах чадвар	4.6 (2022) 4.3
Эмзэг байдал	2.3 (2022) 3.4
Ган, хэт халалт, үер, хөрсний гулсалт, шуурга, хээрийн түймэр	

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гол бодлого, зохицуулалтууд

Монгол улс 1993 онд НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц, 1999 онд Киотогийн протокол, 2016 онд уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрт тус тус нэгдсэн. Монгол улс уур амьсгалын өөрчлөлтийн конвенцоос гадна 1993 онд НҮБ-ын Биологийн олон янз байдлын тухай конвенц, 1996 онд Цөлжилттэй тэмцэх НҮБ-ын конвенц зэрэг олон улсын томоохон гэрээ хэлэлцээрүүдэд нэгдсэн.

Монгол улсад уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах салбар дундын үйл ажиллагааг зохицуулсан тусгай хууль тогтоомж байдаггүй. Одоо хүчинтэй байгаа хуулиудад уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг тусгасан, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагааг дэмжих зарим нэмэлт өөрчлөлтүүд хийсэн байдаг.

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа 2050” нь ядуурлыг бууруулах, нүүрстөрөгч бага ялгаруулдаг ногоон эдийн засгийг бий болгох, боловсролын систем, жендэрийн тэгш байдлыг сайжруулах, нийгмийн хөгжлийг нэмэгдүүлж, даван туулах тэсвэрлэг чадварыг бэхжүүлэх зэрэг есөн үндсэн зорилт бүхий урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг юм. Энэ баримт бичиг нь Тогтвортой Хөгжлийн Зорилгуудад (ТХЗ) хүрэх Монгол Улсын амлалтыг биелүүлэх хүсэл зоригийн илэрхийлэл юм.

Эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, амьжиргааг сайжруулах, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх зорилготой “Шинэ сэргэлтийн бодлого” нь “Алсын хараа 2050” бодлогын гол зорилготой нийцсэн төлөвлөгөө бүхий баримт бичиг билээ. Төлөвлөгөөний гол онцлог нь ногоон хөгжил, ойжуулалт, цөлжилттэй тэмцэх, эрчим хүчний тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх юм. Гэвч уур амьсгалын өөрчлөлтийн талаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, үүнтэй холбоотой үйл ажиллагаанд тэдний оролцоог сайжруулах талаар тодорхой тусгаж өгөөгүй байна.

Хөгжлийн зорилтот хөтөлбөр нь хүний хөгжил, нийгмийн хөгжил, эдийн засаг, дэд бүтцийн хөгжил, байгаль орчин, засаглал, үндэсний өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлогын баримт бичиг юм. Энэ нь “Алсын хараа 2050”-ын зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлогын гол баримт бичиг билээ. Үүнд бүх салбарын оролцоог тодорхойлж, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой зааж өгсөн байдаг. Уг бодлого, ялангуяа “Байгаль орчны зорилтот хөтөлбөр” нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг шийдвэрлэх, хууль эрх зүйн болон бодлогын хүрээг бий болгох, нүүрстөрөгчийн ялгаруулалт багатай, уян хатан эдийн засаг, нийгмийг бий болгох, гамшгийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах стратегийн баримт бичиг болсон. Бодлогын баримт бичигт тусгагдсан дараах зорилтууд нь олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэхэд чухал үүрэгтэй.

5.1.8. Эрт сэрэмжлүүлэх тогтолцоо, дасан зохицох чадавхыг бий болгох.

5.2.2. Байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх хүүхэд, өсвөр үеийнхний мэдлэг, оролцоог аян, санаачилга өрнүүлэх замаар нэмэгдүүлэх.

Гэвч санхүү, техник, хүний нөөц, институцийн хүндрэлээс үүдэн Засгийн газар томоохон сорилтуудтай тулгарч байна. Эдгээр сорилтуудад дараах зүйлс багтана:

- Уур амьсгалын бодлогын зорилтуудыг үндэстний, орон нутгийн болон салбарын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрт хангалттай шигтгэж тусгахгүй байна;
- Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой үйл ажиллагааны санхүүжилтийг салбар хооронд хуваарилах удирдамж заавар байхгүй;
- Төрийн байгууллагуудын чиг үүрэг, бүрэн эрхийг тодорхой заасан зохицуулалт, эрх зүйн орчин сул байна. Чиг үүрэг нь ихэвчлэн БОЯ-нд ногддог;
- Гамшгаас хамгаалах бэлэн байдлын механизм, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадварыг сайжруулах гамшгийн эрсдэлийг зохицуулах чадавх сул;
- Бодлого боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоо дутмаг.

Уур амьсгалын өөрчлөлтийн боловсролын нөхцөл байдал

Сүүлийн 80 жилийн хугацаанд дундаж температур 2.36°C-аар нэмэгдэж, хур тунадас 7%-иар буурчээ. 1960 оноос хойш уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гамшгийн давтамж, эрчим 2.5 дахин нэмэгджээ. Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг-хандлага-практикийн (КАП) судалгаагаар уур амьсгалын өөрчлөлтийг эн тэргүүнд шийдэх асуудал эсэх талаар асуумжид судалгаа өгсөн хүмүүсийн 85.7% нь уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг яаралтай арга хэмжээ авах шаардлагатай гэж хариулсан байна.

Монгол улсын бэлчээрийн талбай нь экологийн хувьд эмзэг бөгөөд цөлжилт бэлчээрийн талбайн 72.8%-д хэдийнээ нөлөөлж эхэлсэн байна (БСҮХ, 2019). Газар тариалан (нүүдлийн мал аж ахуй) нутаг дэвсгэрийн 73.4 хувийг эзэлдэг ба эдийн засаг, хүнсний хангамж нь энэхүү салбараас шууд хамааралтай (БСҮХ, 2019). Тогтворгүй өсөлт нь нөхөн сэргээгдэх байгалийн нөөц, тэр тусмаа бэлчээрийн нөөцөөс давж эхэлж байна.

Хөдөө орон нутагт малчид уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалж зудад нэрвэгдэх давтамж нэмэгдэж, өвөлжилт хүндэрч, бэлчээрийн даац хэтрэх, цөлжилт, уул уурхайн олборлолтын улмаас бэлчээрийн хомсдолд өртөх эрсдэл нэмэгдсээр байна. Гэнэтийн байдлаар малаа алдаж, дараагийн хүндрэлээс өмнө малын тоо толгойг сэргээн нөхөх хугацаа хангалтгүй байгаа нь малчин өрхүүдийг нөхөн үржих капиталаас салгаж байна. Малчдын зуд болон бусад гамшгийг даван туулах стратеги нь уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй цочролын давтамж нэмэгдэж буйтай зэрэгцэх чадвар нь багассаар байна. Ядуурлын босго руу эсвэл түүнээс доогуур орсноор орлогын баталгаа хайн шилжилт хөдөлгөөн хийдэг (Даэйр, 2014). Ядуурал нь тухайн өрхийн хүүхдүүдийг сургуульд үргэлжлүүлэн сургах, дүрэмт хувцас, өвлийн хувцас, сурах бичиг, хичээлийн хэрэгсэл, нийтийн тээвэр, сургуулийн арга хэмжээний гэх мэт сургуулийн "далд" зардлыг зохицуулах эцэг эхийн чадварт нөлөөлнө (Б.Батжаргал, Д.Тунгалаг, 2018).

Мөн боловсролын зорилго нь үндэстний хөгжлийн зорилготой холбогдохгүй байх хэд хэдэн тохиолдол бий. Тиймээс боловсролын тогтолцоо нь өөрийн орны өвөрмөц нөхцөл байдал болон шинээр гарч ирж буй хөгжлийн сорилтуудад, тэр дундаа ТХЗ-13 (Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үйл ажиллагаа)-д болон байгаль орчны бусад асуудлуудад тогтвортой хөгжлийг хангах ба түүнд боловсролын гүйцэтгэх үүрэг зэргийг хараахан хангалттай тооцож шийдвэрлэхгүй байна.

КАП судалгаанд оролцогчдын 92.7% нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар санаа зовниж байгаагаар илэрхийлсэн нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой найдвартай, тогтмол мэдээллийн эрэлт хэрэгцээ өндөр байгааг харуулж байна. Эдгээр нөхцөл байдал цаашид үргэлжилбэл уур амьсгалын өөрчлөлт оролцогчдын амьжиргаанд сөргөөр нөлөөлнө гэж хариулав. Байгаль орчин (51.6%), хүн амын эрүүл мэнд (38.6%), мал аж ахуй, газар тариалан (31.0%) зэрэгт сөрөг нөлөө илрэх бөгөөд эрчим хүчний зардал нэмэгдэх нь улс орны эдийн засагт томоохон нөлөө (20.3%) үзүүлнэ гэж судалгаанд оролцогчид үзэж байна. Эдийн засгийн өргөн хүрээний асуудлуудын хувьд амьжиргааны өртөг нэмэгдэж, хүнсний аюулгүй байдалд аюул учруулах (19.1%), уур амьсгалаас үүдэлтэй шилжилт хөдөлгөөн, залуучуудын боловсрол дутмаг болох, гэр бүл тусдаа амьдрах, улмаар салалт нэмэгдэх зэрэг нийгмийн асуудлыг хурцатгах (13.5%) багтаж байна. Гэсэн хэдий ч судалгаанд хамрагдсан хүн амын дунд уур амьсгалын өөрчлөлт болон нийгэм, эдийн засаг, байгаль орчны бусад асуудал хоорондын хамаарлын талаарх ерөнхий ойлголт харьцангуй бага байсан.

1 БОАЖ, ДАЯН ДЭЛХИЙН НОГООН ХӨГЖЛИЙН ИНСТИТУТ "УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ МОНГОЛЧУУДЫН МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДАЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ СУДАЛГАА", 2023

2 ЮНЕСКО, МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН ТОЙМ ШИНЖЛЭГЭЭ, 2019

Судалгаанд оролцогчдын 13.5% нь уур амьсгалын өөрчлөлтийг нийгмийн асуудалтай, 20.3% нь эдийн засгийн асуудалтай, 51.6% нь байгаль орчны асуудалтай холбосон байна. Ярилцлагад хамрагдсан хүмүүсийн дөнгөж 9.9% нь уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаврыг арилгах стратегийн талаар мэдлэгтэй гэв. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ирээдүйд сөргөөр илрэх (78.6%) боловч ойрын хугацаанд биш (67.1%) гэж тэд үзсэн. Энэ нь ерөнхийдөө уур амьсгалын өөрчлөлтийн өнөөгийн болон таамаглаж буй үр нөлөөний талаарх мэдээлэл дутмаг байсантай холбоотой. Үүнээс харахад хүмүүсийн өөрийгөө болон өрх, нийгмээ хамгаалахад шаардлагатай амин чухал мэдлэг Монгол улсад дутмаг байна.

Боловсролын нийц нь хүмүүс өөрсдийн нөхцөл байдалд боловсролын чанар, зардал, үр ашгийг хэрхэн үнэлж байгаатай салшгүй холбоотой байдаг – шууд хэмжихэд амаргүй ч энэ нь уг асуудалд оролцох өрх гэр бүлүүдийн шийдвэрт нөлөөлдөг (ЮНЕСКО, 2014, 2005).



“Хурдацтай өөрчлөгдөж буй экологийн орчинд уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдлын эсрэг арга хэмжээ авах, одоо байгаа нөлөөллийг багасгах зэрэгт хувь хүний чадавхыг дэмжих боловсролын систем хэрэгтэй.”



Боловсролын нийцийг хүний эрхэм чанарыг хүндэлсэн хөгжлийг хангаж чадаж байгаа эсэхээр нь үнэлж болох юм. Мөн бүх сурагчид уламжлалт болон орчин үеийн эдийн засагт ажиллах үр чадвараа хөгжүүлэх шаардлагатай.

Монголын сургалтын хөтөлбөрт уур амьсгалын өөрчлөлтийн талаар огт дурддаггүй. Цөөн хэдэн боловсролтой холбоотой баримт бичигт уур амьсгалын өөрчлөлтийн талаар дурдагдсан байдаг авч тэдгээр нь тун гүехэн. ТХЗ-4.7 (Тогтвортой хөгжил ба дэлхийн иргэний боловсрол)-ийг Азийн 22 орны боловсролын тогтолцоо, бага, дунд сургуулиудын сургалтын хөтөлбөр, үндсэн хичээлийн хөтөлбөрт тусгасныг тоймлон үзэхэд Монгол улс хүний сайн сайхан байдал, аюулгүй байдал, энх тайван, соёл, байгаль орчныг хамгаалах, байгаль орчны тогтвортой байдал, хүний эрх, эрх чөлөө, өв уламжлал, оршин байх, хамтын ажиллагаа, түншлэл, шийдвэр гаргах, бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх зэрэг чадваруудыг хангалттай түвшинд оруулсан гэж дүгнэжээ.

Гэвч эдийн засгийн тогтвортой байдал, тогтвортой өсөлт, уур амьсгалын өөрчлөлт, хог хаягдлын менежмент, эрүүл амьдралын хэв маяг, нөхөн үржихүйн эрүүл мэнд, жендэрийн тэгш байдал, дэлхийн засаглалын тогтолцоо ба дэвшил, үндэстэн дамнансан корпорацууд, терроризм, ядуурал, тэгш бус байдал, олон янз байдлыг хүндэтгэх болон олон соёлт үзэлийн талаар тусгаагүй, мөн интеграц сэтгэлгээ, системийн сэтгэлгээ, дэлхийн болон орон нутгийн түвшинд авч үзэх болон 21-р зууны үр чадварыг хангалттай багтаагаагүй байна.

Уур амьсгалын өөрчлөлт боловсролын салбарт үзүүлэх нөлөө

НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол дахь судалгаагаар уур амьсгалын өнөөгийн байдал, тухайлбал өвлийн эрс тэс нөхцөл байдал (өвөлдөө зудын байдал хүндрэх, түүхий нүүрсний хэт их хэрэглээнээс шалтгаалсан агаарын бохирдол), зуны улиралд их хур тунадас ихээр орох (үер усны аюулд хүргэх), зун илүү эрс тэс уур амьсгалтай болж (ган гачгаас шалтгаалсан хүндрэлтэй зуд) байна. Эдгээр нь бүгд Монголын боловсролын салбарт сөрөг нөлөө нөлөө үзүүлж байна. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэх гол нөлөө нь боловсролын хүртээмж буурах юм. Хатуу ширүүн, хүйтэн өвлийн улиралд зам нь ашиглах боломжгүй, эсвэл туйлын аюултай болдог. Шар усны үерийн дараа зам эвдэрсэн үед, түүнчлэн эрүүл мэндийн асуудлаас болж хичээлээ таслах, сургуулиа орхих тохиолдлууд гарах ба эдгээр нь ирцийг бууруулж, сургалтын үр дүнд нөлөөлж болзошгүй. Малчин өрхүүд амьжиргаагаа залгуулж, хүүхдээ сургуульд сургах хангалттай орлоготой болох нь цаг агаарын таатай нөхцөлөөс өндөр хамааралтай тул амьжиргааны асуудал ч газар авдаг.

Эдгээр асуудлуудаас гадна ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмж хангалтгүй, хүнсний аюулгүй байдал, эрчим хүчний хүртээмж зэрэг нь уур амьсгалтай холбоотой гамшгийн үед сурагчдын сайн сайхан байдалд нөлөөлж байна гэж сургуулиуд мэдүүлсэн.

Ялангуяа эмзэг бүлгийнхэн харьцангуй илүү өртөх магадлалтай. Энэ нь тэдний цочрол, стресст өртөх, уур амьсгалаас үүдэлтэй гамшиг, эрсдэлийг тэсвэрлэх, хариу арга хэмжээ авах чадвар хязгаарлагдмал байдагтай холбоотой юм. Эмзэг байдлын ерөнхий индексийг ашиглан судалгаанд хамрагдсан нийт 1,313 (46.8%) оролцогчийг “эмзэг” гэж тодорхойлсон.

Судалгаанаас харахад “эмзэг” гэж тооцогддог хүмүүсийн дунд хэд хэдэн нийтлэг эмзэг байдал байгааг харуулсан. Жишээлбэл, бага орлоготой судалгаанд оролцогчдын дийлэнх нь эмэгтэйчүүд (62.1%, 37.9% эрэгтэй), дийлэнх нь хадгаламжгүй (61.9%), дийлэнх нь бүрэн дунд (41.8%) буюу түүнээс доош боловсролтой (24.1%), ойролцоогоор хотын гэр хороололд амьдардаг (27.6%) гэдгийг харж болно.

Боловсролоор дамжуулан уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах үйл ажиллагааг дэмжих иргэний нийгмийн сайн туршлага, хөтөлбөрүүд

Нийслэл Улаанбаатар хот өвлийн улиралд утаа ихтэй ба тоосонцор нь аюултай түвшинд хүрдэг. Энэхүү өндөр бохирдлын түвшин нь нийгмийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж, амьсгалын замын болон бусад өвчлөлийг нэмэгдүүлдгийг судалгаагаар тогтоосон. Статистикийн хувьд, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын (ДЭМБ) мэдээлснээр Улаанбаатар хот нь тоосонцрын бохирдлын хэмжээгээр дэлхийд дээгүүрт ордог бөгөөд PM2.5 (2.5 микрометрээс бага диаметртэй тоосонцор) 2018 оны байдлаар дундаж агууламж нь метр куб тутамд 62 микрограмм байна. Энэ нь ДЭМБ-аас тогтоосон жилийн хэвийн хэмжээнээс 10 дахин их юм.

Дотор болон гадаах орчны агаарын бохирдол нэмэгдэж байгаа нь сурлагын амжилтын үзүүлэлтийг бууруулж, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна. **“Бүх нийт боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл нь 2023 оны 4-р сараас эхлэн дотоод орчны агаарын чанарыг сайжруулах, тэр дундаа сургуулиудын агаарын чанарыг сайжруулах зорилгоор Breathe Mongolia, Цэвэр Агаар Эвсэлтэй хамтран ажиллаж эхэлсэн. Иргэний нийгмийн байгууллагууд хамтран агаарын бохирдлын хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх нөлөөний судалгааны үр дүнд үндэслэн нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, зөвлөмж боловсруулан Боловсролын Ерөнхий Газар, Орчны Бохирдлыг Бууруулах Үндэстний Хороо, Эрүүл Мэндийн Яам, Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яаманд хүргүүлсэн.**

Breathe Mongolia нь ерөнхийдөө хяналтын үүрэг гүйцэтгэдэг эвсэл бөгөөд боловсрол, лоббигоор дамжуулан иргэдийн зөв зан үйлийн мэдлэг тараах зорилготой. Энэхүү цэвэр агаарын эвсэл нь олон нийттэй хамтран ажиллахаас гадна хэрэгцээт зөвлөгөө хүргэх, асуудалд хувь нэмэр оруулах боломжтой онлайн төвийг бий болгосон.

Хүмүүст мэдлэг олгох зорилго бүхий олон төсөл явагдаж байна. Хамгийн өндөр үр нөлөөтэй нь Монголын Финтек групп компани болох Hi-Pay болон Airly компани хамтран Монгол Улсын агаарын бохирдлын талаарх бодит мэдээллийг иргэдэд шууд мэдээлж байх санаачилга юм. Hi-Pay програм нь банкны үйлчилгээ үзүүлэхээс гадна Airly дээр суурилсан амьдралын хэв маяг, хүрээлэн буй орчны талаарх мэдээллийг хүргэдэг. Уг программд өдөрт дунджаар 300,000 гаруй харилцаа бүртгэгдэж байгаа нь Монгол Улсын хүн ам энэ асуудалд хэр их анхаарч буйг харуулж байна.

III. ТХЗ-4 ДЭХ НИЙГМИЙН ОРОЛЦОО, ХЭРЭГЖИЛТ, ХЯНАЛТ

Тогтвортой хөгжлийн зорилгуудын дэд хорооны ажлыг дэмжих, УИХ, Засгийн газар, хөгжлийн түншүүд, иргэний нийгмийн байгууллагууд, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийн олон талт хамтын ажиллагаа, оролцоог өргөжүүлэх зорилгоор Тогтвортой хөгжлийн олон талт зөвлөлийг 2022 онд байгуулсан. Энэ нь ТХЗ-ын төлөвлөлт, санхүүжилт, хэрэгжилтийг эрчимжүүлэх үүрэгтэй, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх, шийдвэр гаргахад шинжээчийн зөвлөмж өгөх, ТХЗ-ын талаарх мэдээллийг олон нийтэд мэдээлэх, түгээх зэрэг үүрэгтэй.

Тогтвортой хөгжлийн үндэсний хороонд засгийн газар, төрийн бус, эрдэм шинжилгээний болон хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл байдаг. Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Үндэсний сайн дурын илтгэл (VNR) болон ТХЗ-4-ийн ахиц дэвшлийн дунд хугацааны тайлан бичих үйл явц зэрэг ТХЗ болон ТХЗ-4-ийг хэрэгжүүлэх, хяналт мониторинг хийх, мөрөөр нь авах арга хэмжээ, ахиц дэвшлийг хянаж үнэлэх үйл явцууд нь нь нээлттэй бөгөөд нийгмийн оролцоог дэмждэг.

Тогтвортой хөгжлийн зорилгын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Үндэсний сайн дурын хоёрдугаар тайлан (ҮСДТ) бэлтгэхийн тулд засгийн газар, ИНБ, хувийн хэвшил, үйлдвэрчний эвлэл, үндэсний хүний эрхийн байгууллагууд, олон улсын хөгжлийн байгууллагууд зэрэг бүх салбар, оролцогч талуудын саналыг дэмжих зорилгоор арав гаруй хэлэлцүүлгийг зохион байгуулсан.

“Тогтвортой хөгжлийн төлөө ИНБ-ын сүлжээ”-ний гишүүд хамтран ТХЗ-ын хэрэгжилтийг А4SD байгууллагын онооны аргачлалаар үнэлэв. Хоёр дахь үнэлгээг салбарын яам, агентлаг, орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, олон улсын байгууллага, судлаачид, хувийн хэвшлийн төлөөллүүд зэрэг олон талын төлөөлөл оролцон хийсэн.



ИНБ-ын үнэлгээгээр ТХЗ-ын хэрэгжилт ерөнхийдөө -1.1 оноо авсан нь ТХЗ-ын хэрэгжилт дорвитой үр дүнд хүрээгүй, ахиц дэвшил гараагүй, ухралт ажиглагдсан гэсэн үг юм. Олон талын оролцогчдын үнэлгээгээр ТХЗ-ын хэрэгжилтэд өөрчлөлт ороогүй гэж дүгнэсэн (нийт оноо 0.09).

ҮСДТ-гийн агуулгыг сайжруулахын тулд “ТХ-ийн төлөөх ИНБ-ын сүлжээ” (БНБТ ИНУЭ нь ТХЗ-4-ийг хариуцдаг гишүүн) мэдээлэл, санал солилцох замаар нягт хамтран ажиллаж, Засгийн газар, ИНБ-ууд хөгжлийг төлөвлөх, хэрэгжүүлэх институтийн бүтцийг сайжруулах, хөгжлийн бодлого, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, урт хугацааны бодлогыг дунд, богино хугацааны бодлого болгон хөрвүүлэх механизмыг боловсронгуй болгон хэрэгжүүлэх, мэдээллийн бүх түвшинд нээлттэй, хяналттай байх нь хариуцлагыг дээшлүүлэх, ТХЗ-ын хэрэгжилт, бодит үр дүнд хүрэхэд нэн чухал гэдэг дээр санал нэгдсэн.

УИХ, Засгийн газар НҮБ-тай хамтран 2021 оны 10 дугаар сарын 4-ний өдөр Тогтвортой хөгжлийн зорилгын Үндэсний дээд түвшний анхдугаар чуулганыг Монгол Улсад анх удаа зохион байгууллаа. Чуулганд 200 орчим зочид, төлөөлөгчид биечлэн болон цахимаар оролцов. ТХЗ-уудын Монгол улс дах хэрэгжилтийн ИНБ-ын үнэлгээний дүгнэлт, үр дүнг ИНБ-ын төлөөлөгч танилцуулж, зөвлөмжийг оролцогч талуудад уламжилсан.

ЮНЕСКО-гийн боловсрол ба суралцахуйг хувирган өөрчлөх дэлхийн энэхүү томоохон санаачилгыг дэмжих орны нэгээр Монгол Улс сонгогдсон. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд БОАЖЯ-аас “Монгол Улсын ТХЗ-4-ийн эхний 5 жилийн хэрэгжилтийн тойм тайлан”-г боловсруулжээ. Үнэлгээг ЮНЕСКО-гийн үндэсний шинжээчид, БШУЯ-ны мэргэжилтнүүд, салбарын холбогдох агентлагууд, “Бүх нийт боловсролын төлөө” эвсэл зэрэг боловсролын оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн судалгааны баг хийсэн.

IV. ЗӨВЛӨМЖ

Боловсролын сургалтын хөтөлбөр, сурах бичигт уур амьсгалын тэнцвэртэй байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны тогтвортой байдлын тухай ойлголт, түүнчлэн тогтвортой үйлдвэрлэл, хэрэглээнд шаардагдах мэдлэг, ур чадвар, оролцоог бага наснаас нь хөгжүүлэх агуулгыг нэвтрүүлэх шаардлагатай.

Байгаль орчны тогтвортой байдал, хүний сайн сайхан байдал ба оршин тогтнол болон тогтвортой үйлдвэрлэл ба хэрэглээ зэрэг ерөнхий агуулгын хүрээг багтаасан уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагааны зорилтот хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.

Олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, тэр дундаа багш нарын энэ сэдвээрх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх нь чухал. Боловсролын байгууллага, сурган хүмүүжүүлэгч, сургагч багш нар уур амьсгалын өөрчлөлтийн талаарх олон нийтийн мэдлэгийг бага наснаас нь нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

Байгаль орчин, цаг уурын үзүүлэлтүүдийг Боловсролын Салбарын Мэдээллийн Систем (БМСМ)-д тусгаж, уур амьсгалд тэсвэртэй байдлын төлөвлөлтөд тусгахын тулд дүн шинжилгээ хийж байх.

Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл, агаарын бохирдлын талаар боловсролын салбарт зориулан эмзэг байдлын үнэлгээ хийж, уур амьсгалын өөрчлөлтийн боловсролд үзүүлж болзошгүй нөлөөний талаар иж бүрэн тоймыг гаргахын тулд цаашид улс орны бусад бүс нутагт зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах.

Боловсролын хүртээмж нь уур амьсгалтай холбоотой томоохон гамшгийн үед тулгардаг гол бэрхшээлүүдийн нэг юм. Аливаа боловсролын байгууламжийг төлөвлөх, барихдаа уур амьсгалтай холбоотой эрсдэлийг харгалзан үзэх ёстой. Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг авч үзсэн удирдамж, стандартыг боловсруулах нь сайн төлөвлөлтийн томоохон эхлэл болно.

Явуулын гэр сургууль, зайн сургалт зэрэг боловсролын өөр арга боломжуудыг судалж, төлөвлөлтийн үйл явцад нэгтгэн нэвтрүүлж, ялангуяа алслагдсан хөдөө орон нутагт системтэйгээр нэвтрүүлэх хэрэгтэй.

Уур амьсгалын шинжлэх ухаан, бодлогын арга хэмжээний талаарх хамгийн сүүлийн үеийн мэдлэгийг тусгах үүднээс үндэсний хичээлийн хөтөлбөрийг шинэчлэх нь хүүхдүүдийг өөрчлөлтийн эзэн байх боломжийг хангах эхний чухал алхам болно.

Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой гамшигийг сөрөх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох асуудлыг боловсролын салбарын төлөвлөлтөд тусгах зорилгоор боловсролын салбарт тусгайлан зориулсан уур амьсгалын санхүүжилт болон гэнэтийн байдлын санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх.



МОНГОЛЫН ЗАЛУУЧУУД: ХЭТИЙН ТӨЛӨВ ЗӨВЛӨМЖ

36

Залуучууд нийгэм, эдийн засаг, байгаль орчны өөрчлөлтийг хөдөлгөх чадвартай учраас Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын (ТХЗ) хүрээнд чухал үүрэг гүйцэтгэдэг. Залуучууд шинэлэг шийдлүүдийг санал болгож, бодлогын өөрчлөлтийг сурталчилж, засгийн газруудад хариуцлага тооцох замаар ТХЗ-д ихээхэн хувь нэмэртэй.

Монгол бол харьцангуй “залуучууд”-ын орон. Монгол Улсын 15-34 насны залуучууд нийт хүн амын гуравны нэг орчим буюу 30.7 хувийг эзэлж байна.



МОНГОЛД



- Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль гарсан ч хэрэгжүүлэх төсөв байхгүй
- Залуучуудын хөгжлийг хариуцдаг үндэсний болон орон нутгийн зөвлөлүүд байдаг ч идэвх, оролцоо дутмаг.
- 2015 оноос хойш яамд, залуучууд тэргүүтэй, залуучуудад суурилсан ИНБ-уудтай хамтран “Залуучуудын хөгжлийн форум”-ыг зохион байгуулж байгаа ч форумын зөвлөмж, саналыг хүлээн аваагүй, бодлогын өөрчлөлт, хэрэгжилтийг сайжруулахад хувь нэмрээ оруулаагүй байна.

Монгол залуусын бичиг үсэг тайлагдсан байдал өндөр. Дийлэнх залуучууд дунд сургуулийн боловсролтой, 25% нь коллеж, их дээд сургууль төгссөн. Есөн жилийн албан журмын боловсролыг обүх нийтээрээ эзэмшсэн.



Шүүмжлэлт сэтгэгчид, өөрчлөлт гаргагчид, шинийг санаачлагч, нийтэч, удирдагчдын хувьд залуучууд шаардлагатай ур чадвар, дэмжлэгээр эрхлэмдэлжсэн тохиолдолд 2030 он гэхэд илүү сайн дэлхийг бий болгох чадварыг эзэмшинэ.

15-29 насны таван монгол залуу тутмын нэг нь Боловсрол, Ажил эрхлэлт болон Сургалтанд огт хамрагдаагүй (NEET).

Ажиллах хүчний судалгаа, хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын статистикаар 15-29 насны хүмүүсийн 41.2 хувь нь ажил эрхэлдэг, 38.1 хувь нь боловсрол, сургалтад хамрагдсан, үлдсэн 20.7 хувь нь алинд ч хамрагдаагүй байна. 2020 оны байдлаар нийт 137,000 монгол залуусын талаас илүү нь буюу 58.9% нь залуу эмэгтэйчүүд байна. Тэдний тал орчим хувь нь нийслэл Улаанбаатар хотод амьдардаг.

Боловсрол, Ажил эрхлэлт болон сургалтын үйл ажиллагаанд оролцоогүй залуусын түвшин орлого өндөр өрхийн залуучуудын дунд бага байна. Боловсролын түвшингээр нь авч үзвэл 34.1% нь дээд, 23% нь техникийн болон мэргэжлийн боловсрол, 30.2% нь бүрэн дунд боловсрол эзэмшжээ. Энэ нь залуучуудын боловсролын түвшин өндөр байгаа нь хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцох, ажил эрхлэлтийн баталгаатай байдалд шууд нөлөөлдөггүй гэсэн үг юм.



ЗАЛУУЧУУДЫН ЗӨВЛӨМЖ

Нийгэм-эдийн засгийн саад бэрхшээл- Амьжиргааны баталгаажих түвшний хүмүүсийн бакалаврын зэрэгтэй байх магадлал ядуу хүмүүсийнхээс долоо дахин, магистрын зэрэгтэй байх магадлал 33 дахин их байна (UNDP, 2016).

Алслагдсан байдал- Дээд боловсролын ихэнх байгууллагууд Улаанбаатар хотод төвлөрдөг тул орон сууцны үнэ, амьжиргааны өртөг өндөр байгаа нь хөдөө орон нутгийн оюутнуудад дээд боловсрол эзэмшихэд бэрхшээл болдог.

Нийслэл рүү **шилжин суурьших нь** чанартай боловсрол эзэмших, хувь хүний сурч боловсрох эрхийг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байна. 15-29 насны залуучуудын 55 хувь нь нийслэлийн захын гэр хороололд амьдардаг (Бодлогод Залуусын Хяналт ТББ, 2019). Гэр хороололд ажлын байр, чанартай боловсрол, бусад үйлчилгээний хүртээмж тааруу бөгөөд ихэнхдээ хөдөө орон нутгаас шилжин ирсэн иргэд амьдардаг.

- Жендэрт мэдрэмжтэй сургуулийн дэд бүтэц, болон хувирган өөрчлөх жендэрийн боловсрол, сургалтын хөтөлбөрт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ёстой. Сургагчдад ээлтэй сургуулийн дэд бүтэц, хандлага арга зүй, дүрэм журам, түүнийг хэрэгжүүлэхэд хангалттай төсөв байх
- Багш нар болон нийт хүн амын дунд жендэрийн тогтсон хэм хэмжээ, хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн, тэдэнд зориулсан сурталчилгаа, хэлэлцүүлэг, сургалтыг хэрэгжүүлэхэд анхаарах.
- Багшийн хөгжил, боловсролын манлайлал дахь жендэрийн ялгаа, жендэрийн хэвшмэл ойлголтыг арилгахын тулд тогтолцоогоор нь харж үйл ажиллагааны төлөвлөгөө батлах.
- Иргэний боловсролоор дамжуулан эрхэд суурилсан хандлага, арга зүйн хүрээнд нийгмийн хүлцэн тэвчихүй, олон янзат байдлыг хүлээн зөвшөөрөх талаарх ойлголтыг оруулах



Үндэс угсаа - Үндэсний цөөнх залуус багш, сурган хүмүүжүүлэх арга зүй, хуулийн хэрэгжилтийн дутагдалтай байдалтай тэмцэж байна.

Хүйсийн ялгаатай байдал байгаа бөгөөд нийгэм, эдийн засгийн янз бүрийн бүлгүүдийн боловсрол эзэмших боломж эрх тэгш бус байна. LGBTQI+ залуучууд гутаан доромжлол, адлал, ялгаварлан гадуурхалттай тулгардаг.

Хөгжлийн бэрхшээл- Хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын дөнгөж 66.2 хувь нь заавал эзэмших боловсролын насны ангилалд хамрагддаг. Төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй залуучуудын бараг тал хувь нь боловсролгүй, бичиг үсэг тайлагдаагүй. Багш нар тэгш хамруулх боловсролын зохих бэлтгэлгүй, дэд бүтэц хүртээмжгүй, алслагдсан сум, аймгийн хэмжээнд тэгш хамруулан сургах, тэгш хүртээмжтэй болгоход хөрөнгө оруулалт дутмаг байна.

- МСҮТ сургалтын хөтөлбөрүүд нь ажилд шаардагдах зохих үр чадварыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ба ажил хийж буй хүмүүст чиглэсэн хөтөлбөрөөр дамжуулан үр чадвараа дээшлүүлэх боломжийг олгох
- Дотоодын хөдөлмөрийн зах зээлийн бүтэц, эрэлт хэрэгцээ, онцлогт тохирсон боловсролын хөтөлбөрүүдийг тогтмол санал болгох
- Дадлага хийх, ажлын байран дээрх сургалт, практик сургалтын материал, тоног төхөөрөмж бэлдэх
- Суралцах чиглэл, мэргэжил сонголтын талаар мэдээлэлтэй сонголт хийхэд чиглэсэн ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх
- Залуучууд болон тэдний эцэг эхчүүдэд МСҮТ-ийг сурталчлах
- Тусгай зөвшөөрөл, итгэмжлэл, хяналт шалгалт, баталгаажуулалт зэрэг чанарын баталгаажуулалтын механизмын хэрэгжилтийг хангах.
- Ажил олгогчийн шаардлага болон төгсөгчдийн үр чадварын хоорондын зөрүүг арилгахын тулд сургалтын хөтөлбөрийнхөө чанар, хамаарлыг сайжруулах
- Хангалттай санхүүжилттэй насанд хүрэгчдийн боловсролын талаарх бодлого, зохицуулалтыг багтаасан үндэсний тогтолцоог батлах
- Боловсролын төрөл, түвшний доторх болон хоорондын шилжилтэд анхаарал хандуулах нь насан туршийн боловсролд цогц анхаарал хандуулахад дэмжлэг болно.
- Салбарын хэмжээнд боловсруулсан төрийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрт хяналт-шинжилгээ, баталгаажуулалтын үндэсний тогтолцоо, тогтолцоог бэхжүүлэх; болон оролцогч талуудын хамтын ажиллагааны уялдаа холбоог сайжруулах

Чанартай боловсрол дутмаг байгаа нь техникийн болон мэргэжлийн сургалтын байгууллагуудын санаа зовоосон асуудал юм.

Боловсролын байгууллагуудын санал болгож буй практик сургалт хангалтгүй, дадлага хийх боломж хомс байгаа нь асуудал болж буй.

Бүх нийт боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл (AFE Mongolia)

Хаяг: 3 тоот, Шүрэн барилга, Элчингийн гудамж, 4-8, 1-р хороо, Сүхбаатар дүүрэг, 14200 Улаанбаатар хот, Монгол Улс
Утас/факс: 7000 8292, 8818 6672, 9663 3360
Email: info@all4education.mn | Website: <http://www.all4education.mn>

Бүх нийт боловсролын төлөө! Иргэний нийгмийн үндэсний эвсэл (Боловсрол эвсэл) нь Иргэний Нийгмийн Боловсролын Сан (CSEF)-ийн дэмжлэгтэйгээр 2010 онд байгуулагдсан бөгөөд Боловсролыг бүх нийтэд! (EFA) зорилтуудыг улс орондоо хэрэгжүүлэхийн төлөө ажилладаг. Эвсэл нь шийдвэр гаргах бүх түвшинд иргэд, иргэний нийгмийн оролцоог утга учиртай, үр дүнтэй болгох институцичлагдсан сувгийг бий болгож бэхжүүлэх, олон талт зөвлөлдөх механизмыг институцижуулах, тасралтгүй нөлөөлөх зорилгоор боловсролын бодлого, тогтолцоонд үндэсний хэмжээнд тогтвортой өөрчлөлт хийхээр ажилладаг. Боловсролын бодлогын шинэчлэл нь хүн бүрийн насан туршийн чанартай боловсрол эзэмших эрхийг хангахын зэрэгцээ хүний эрхэд суурилсан хандлагыг хэрэгжүүлэх, гадуурхагдсан хүмүүсийн дуу хоолойг нэмэгдүүлэх учиртай. Боловсрол эвсэл нь ASPBAE-ийн гишүүн байгууллага юм.



With support from

